

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/137/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал Утас: 326734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn</p> <p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер:Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Н.Баттогоо Утас: 325093 Цахим хаяг: battogoon@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Соёлын төв өргөө Г корпус, 5 давхар,
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026-03-13 № 299
танай _____-ны № _____-т

УЛААНБААТАР ХОТЫН УС СУВГИЙН
УДИРДАХ ГАЗАР ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Ц.ТӨРХҮҮ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 1,438.4 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх", "үнэн зөв байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

НИТХ 2024 оны 114 дүгээр тогтоол, НЗД 2024 оны А/1293 дугаар захирамжаар Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банкны санхүүжилтээр хийгдсэн Морингийн даваа орчмын шинэ суурьшлын бүсийн усан сан, насос станцын барилга, шугам сүлжээ зэрэг нийт 27,282.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэж, нягтлан бодох бүртгэлд тайлагнасан байна.

1426052027

C:\Users\hanangua\Desktop\6666\хагар 2026\2025\word\ywsan bichig\Dugnet_2026.docx

Аудитын гол асуудал

Тус ОНӨААТҮГ нь 2025 оны зорилтот түвшингээр үндсэн үйл ажиллагаанаас 134,908.1 сая төгрөг, үйл ажиллагааны бус 10,784.3 сая төгрөг нийт 145,692.4 сая төгрөгийн орлого төлөвлөсөн байна. Тайлант онд гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 133,427.3 сая төгрөг ба төлөвлөгөөний биелэлт 98.9 хувиар, үйл ажиллагааны бус 17,561.6 сая төгрөгийн орлого олж, төлөвлөгөөнөөс 62.8 хувиар давуулж биелэсэн боловч үйл ажиллагааны алдагдал нөлөөлж 11,937.3 сая төгрөгөөр алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 69 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92.7 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	87,730,780,102.30	68,700,426,349.71
1.1.2	Дансны авлага	9,885,814,586.78	10,836,962,288.10
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	1,473,738,911.99	1,962,190,007.47
1.1.4	Бусад авлага	41,846,566.35	55,957,656.37
1.1.6	Бараа материал	13,018,966,779.10	10,983,905,590.86
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	399,745,111.05	18,410,617,353.44
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	112,550,892,057.57	110,950,059,245.95
1.2.1	Үндсэн хөрөнгө	274,493,676,875.02	288,694,881,268.56
1.2.2	Биет бус хөрөнгө	113,077,871,785.53	114,636,616,756.18
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	22,190,750.95	1,994,232,417.65
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	387,593,739,411.50	405,325,730,442.39
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	500,144,631,469.07	516,275,789,688.34
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1.1	Дансны өглөг	525,830,140.15	84,919,137.20
2.1.1.2	Цалингийн өглөг	460,045,773.00	
2.1.1.3	Татварын өр	2,354,579,073.86	1,341,837,819.26
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Банкны богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	967,282,878.24	1,149,989,427.03
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	704,770,535.00	1,945,523,446.43
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,012,508,400.25	4,522,269,829.92
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	125,226,905.40	1,988,943,195.31
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	125,226,905.40	1,988,943,195.31
2.2	Өр төлбөрийн нийт дүн	5,137,735,305.65	6,511,213,025.23
2.3	Өмч:	874,877,566.30	874,877,566.30
2.3.1	-төрийн	874,877,566.30	874,877,566.30
2.3.3	-хувьцаат	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	111,788,353,550.49	111,748,436,891.85
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	460,841,635,873.30	490,090,741,073.92
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(78,497,970,826.67)	(92,949,478,868.96)
2.3.11	Эздийн өмчийн дүн	495,006,896,163.42	509,764,576,663.11
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	500,144,631,469.07	516,275,789,688.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	131,504,191,360.25	133,427,288,952.12
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	119,507,062,113.85	142,808,255,573.17
3	Нийт ашиг (алдагдал)	11,997,129,246.40	(9,380,966,621.05)
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	2,565,338,661.68	2,342,458,774.38
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Бусад орлого	8,198,675,559.71	15,214,725,764.63
8	Борлуулалт, маркетингийн зардал	3,831,058,364.08	4,918,092,275.91
9	Ерөнхий ба удирдлагын зардал	5,149,447,836.98	6,476,388,272.78
10	Санхүүгийн зардал		
11	Бусад зардал	4,680,880,993.22	8,488,241,357.73
12	Гадаад валютын ханшийн зөрүү ний олз (гарз)	258,464.19	3,426,713.43
13	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
14	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Бусад ашиг (алдагдал)	-	-
16	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	9,100,014,737.70	(11,703,077,275.03)
17	Орлогын татварын зардал	2,792,731,864.00	234,245,877.44
18	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	6,307,282,873.70	(11,937,323,152.47)
19	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
20	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	6,307,282,873.70	(11,937,323,152.47)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	6,307,282,873.70	(11,937,323,152.47)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	874,877,566.30	111,919,323,994.14	458,570,138,667.30	(83,253,400,028.74)	488,110,940,199.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл	874,877,566.30	111,788,353,550.49	460,841,635,873.30	(78,497,970,826.67)	495,006,896,163.42
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					-
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт					-
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	874,877,566.30	111,788,353,550.49	460,841,635,873.30	(78,497,970,826.67)	495,006,896,163.42
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
11	Залруулсан үлдэгдэл	874,877,566.30	111,788,353,550.49	460,841,635,873.30	(78,497,970,826.67)	495,006,896,163.42
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(11,937,323,152.48)	(11,937,323,152.48)
13	Бусад дэлгэрэнгүй орлого					-
14	Өмчид гарсан өөрчлөлт			29,249,105,200.62	(2,514,184,889.81)	26,734,920,310.81
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(39,916,658.64)			(39,916,658.64)
17	2025 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	874,877,566.30	111,748,436,891.85	490,090,741,073.92	(92,949,478,868.96)	509,764,576,663.11

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн	158,344,353,335.45	167,015,162,865.89
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	146,907,705,236.81	148,048,219,514.27
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	12,615,500.00	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	4,128,883,626.53	12,001,777,060.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	7,295,148,972.11	6,965,166,291.62
1.2	Мөнгөн зарлагын дүн	120,379,926,545.34	173,145,606,540.95
1.2.1	Ажиллагчдад төлсөн	51,024,202,794.97	67,062,721,028.50
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	15,155,176,689.01	19,946,660,562.32
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	6,915,639,620.73	10,576,740,342.15
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	20,019,181,811.67	25,005,976,302.55
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,178,394,931.91	3,331,595,205.45
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	16,519,353,203.42	20,667,416,465.27
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	158,858,112.70	79,081,762.78
1.2.9	Бусад мөнгөн зарлага	6,409,119,380.93	26,475,414,871.93
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	37,964,426,790.11	(6,130,443,675.06)
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	9,596,926,254.33	12,903,336,790.96
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9,560,643,574.33	12,304,725,734.96
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	36,282,680.00	598,611,056.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(9,596,926,254.33)	(12,903,336,790.96)
3.1	Мөнгөн орлогын дүн	698,728.72	4,465,213.66
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.4	Бусад	698,728.72	4,465,213.66
3.2	Мөнгөн зарлагын дүн	440,264.53	1,038,500.23
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5	Бусад	440,264.53	1,038,500.23
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	258,464.19	3,426,713.43
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	28,367,758,999.97	(19,030,353,752.59)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	59,363,021,102.33	87,730,780,102.30
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	87,730,780,102.30	68,700,426,349.71

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/ мянган төгрөгөөр/

№	Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /илүү+ дутуу-/	Хувь
1	Нийт орлогын дүн	134,908,092.3	133,427,288.9	(1,480,803.5)	98.9
1.1	Цэвэр усны орлого	73,225,336.2	72,850,265.2	(375,071.0)	99.5
1.2	Бохир ус татан зайлуулсан орлого	58,084,589.1	57,138,224.4	(946,364.6)	98.4
1.3	Бусад орлого	3,598,167.1	3,438,799.2	(159,367.9)	95.6
2	Нийт зардал	173,552,608.4	154,202,736.1	(19,349,872.3)	88.9
2.1	Үндсэн ба нэмэгдэл цалин	71,489,578.5	65,295,927.4	(6,193,651.1)	91.3
2.20	Ажил олгогчоос эмнэлгийн хуудсаар олгосон	130,250.0	223,450.4	93,200.4	171.6
2.3	НДШ, ЭМД	11,807,644.7	10,720,821.6	(1,086,823.1)	90.8
2.4	Хоол, унаа	16,522,093.5	15,055,812.5	(1,466,281.0)	91.1
2.5	Сургалт	319,809.0	136,690.8	(183,118.2)	42.7
2.6	Тэтгэмж болон нийгмийн арга хэмжээ	712,376.8	439,795.1	(272,581.7)	61.7
2.7	Шагнал	55,540.0	36,741.5	(18,798.5)	66.2
2.8	Хлор, манганы сульфат, бодис, давс	1,970,903.1	1,168,597.9	(802,305.2)	59.3
2.90	Сэлбэг, багаж хэрэгсэл	3,961,973.2	2,614,340.2	(1,347,633.0)	66.0
2.10	Хангамжийн зардал	178,491.6	137,638.0	(40,853.6)	77.1
2.11	Түлээ, нүүрс	41,230.0	44,029.9	2,799.9	106.8
2.12	Шатахуун, тосолгоо	3,823,235.8	2,170,806.1	(1,652,429.7)	56.8
2.13	Цахилгаан	23,580,641.4	21,890,231.6	(1,690,409.8)	92.8
2.14	Дулаан, СӨХ	720,315.9	409,661.3	(310,654.6)	56.9
2.15	Ус	37,909.9	26,710.4	(11,199.5)	70.5
2.16	Харуул, хамгаалалт	691,838.4	411,695.6	(280,142.8)	59.5
2.17	Урсгал засвар, аваар,аваарын нөөц сан, тохижилт	1,603,948.6	1,148,179.7	(455,768.9)	71.6
2.18	Лагийн зардал	125,843.4	67,130.8	(58,712.6)	53.3
2.19	Бичиг хэрэг	115,519.3	78,761.0	(36,758.3)	68.2
2.20	Холбоо шуудан холбоо, хэвлэл захиалга	333,496.9	285,318.2	(48,178.7)	85.6
2.21	Томилолт	188,733.9	101,003.9	(87,730.0)	53.5
2.22	Зар сурталчилгаа, олон нийтийн зардал	184,500.0	155,350.8	(29,149.2)	84.2
2.23	Гаднын үйлчилгээ	82,947.9	67,520.8	(15,427.1)	81.4
2.24	Банкны үйлчилгээ	15,938.1	5,070.3	(10,867.8)	31.8
2.25	Хөдөлмөр хамгаалал	1,924,040.0	1,520,620.3	(403,419.7)	79.0
2.26	Лабораторийн зардал	341,725.8	176,926.7	(164,799.1)	51.8
2.27	Төслийн зардал	350,881.3	286,819.9	(64,061.4)	81.7
2.28	УЗ-ын зардал	79,856.4	69,961.3	(9,895.1)	87.6
2.29	Найдваргүй авлагын зардал	52,296.7	39,701.3	(12,595.4)	75.9
2.30	Татвар, хураамж	1,693,241.3	1,503,349.3	(189,892.0)	88.8
2.31	Даатгал	58,697.1	55,919.0	(2,778.1)	95.3
2.33	Элэгдэл	30,357,109.9	27,858,152.5	(2,498,957.4)	91.8
3	Үйл ажиллагааны алдагдал	(38,644,516.1)	(20,775,447.2)	17,869,068.8	53.8
4	Үйл ажиллагааны орлогын нэг төгрөгт ногдох зардал	1.29	1.16	(0.13)	89.8
5	Үйл ажиллагааны бус орлого	10,784,272.7	17,561,649.8	6,777,377.1	162.8

6	Үйл ажиллагааны бус зардал	6,807,381.2	8,489,279.9	1,681,898.7	124.7
7	Нийт орлого	145,692,365.0	150,988,938.6	5,296,573.6	103.6
8	Нийт зардал	180,359,989.6	162,692,016.0	(17,667,973.6)	90.2
9	ОНТНЗ	1.24	1.08	(0.16)	87.0
10	Татвар төлөхийн өмнөх алдагдал	(34,667,624.6)	(11,703,077.3)	22,964,547.3	33.8
11	Орлогын татварын зардал		234,245.9	234,245.9	
12	Тайлант үеийн цэвэр алдагдал	(34,667,624.6)	(11,937,323.2)	22,730,301.4	34.4
13	Авлага	9,885,814.6	10,836,962.3	951,147.7	109.6
14	Нийт өр төлбөр	5,137,735.3	6,511,213.0	1,373,477.7	126.7
15	Хөрөнгө оруулалт	17,591,400.0	12,903,336.8	(4,688,063.2)	73.4
16	Орон тоо	1,943	1,750	(193.0)	90.1

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулагдаагүй нийт 1,438,442.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 51,317.0 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт 493,281.5 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага, 893,844.4 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,438,442.9 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их тул “Хязгаарлалтай” санал дүгнэлт өглөө.

Дөрөв. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨТҮГ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Авто тээврийн хэрэгслийн тооллогоор нийт 160 авто тээврийн хэрэгслээс 2.4 тэрбум төгрөгийн 24 тээврийн хэрэгсэл нь эвдэрч ашиглалтгүй, үүнээс ашиглалтын хугацаа дуусаагүй 2019-2024 оны 615.4 сая төгрөгийн өртөгтэй 6 тээврийн хэрэгсэл нь эвдэрч, байгууллагын авто бааз хашаанд ашиглалтгүй парктасан байдалтай байна.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
2	Газрын даргын тушаал шийдвэргүй, бараа материал устгасан акт үйлдээгүй, өмч хамгаалах байнгын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлд актлах материалыг хоёрдогч түүхий эдээр борлуулах, хогонд ачих зэргийг дурдаагүй нийт 4370 нэр төрлийн 184,255.2 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлээс хасаж тайлагнасан байна.	1	184,255.2	-	-	1	184,255.2	-	-	-	-	-	-	-
3	Түүвэр тооллогоор 3 албаны 4 эд хариуцагчийн 77,402 ширхэг 5,307,761.3 мянган төгрөгийн агуулахад бэлэн байгаа сэлбэг, хангамжийн материалыг тооллого хийхэд нийт илүүдсэн 185.3 мянган төгрөг, дутагдсан 9,391.7 мянган төгрөгийн сэлбэг, хангамжийн	1	9,577.0	1	9,577.0	-	-	-	-	-	-	-	-	-

	материал байна. /ШАУЗА-7,474.7 мянган төгрөг, АБ-1,924.0 мянган төгрөг, ЦБА-178.4 мянган төгрөг/.												
4	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлээгүй сэлбэг материалын зардалд 151,905.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	151,905.7	-	-	-	-	1	151,905.7	-	-	-	-
5	Бараа материал дансанд хөдөлгөөн ороогүй, нэмж орлого авсан, ашиглагдаагүй хөрөнгүүд байна. /АБ-113,730.7 мянган төгрөг, УЦБА-25,711.2 мянган төгрөг, ХҮА 45,364.7 мянган төгрөг ЦБА-63,142.4 мянган төгрөг, ЗУХА-44,216.2 мянган төгрөг/	1	292,165.2	-	-	-	-	1	292,165.2	-	-	-	-
6	Урсгал засварын зардалд бүртгэсэн өндөр өртөгтэй насос, хаалт, цайрдсан ган труба гэх мэт хөрөнгүүд, их хэмжээгээр зарцуулсан материалуудад ил, далд ажлын актууд үйлдээгүй, хүлээлцсэн акт баримтгүй, зарцуулсан ажлын тайлан байхгүй зэрэг анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн байна. /ШАУЗА-143,205.9 мянган төгрөг, УЦБА-9,876.2 мчнган төгрөг, ХҮА-15,687.1 мянган төгрөг, ЗУХА-12,694.1 мянган төгрөг, УХА-232,889.9 мянган төгрөг/	1	449,773.5	-	-	-	-	1	449,773.5	-	-	-	-
7	Тайлант онд авлага нэмэгдсэн, тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулаагүй.	1	66,686.3	-	-	1	66,686.3	-	-	-	-	-	-
8	Тайлант онд орлого авсан тээврийн хэрэгсэл, зарим компьютерт, тоног төхөөрөмжийн ашиглагдах жилийн бага хугацаагаар тооцож, элэгдлийн зардалд нэмэгдүүлж бүртгэсэн байна. /АБ-76,711.2 мянган	1	370,195.3	-	-	-	-	1	370,195.3	-	-	-	-

	төгрөг, МТА-39,620.2 мянган төгрөг, ЦБА 242,081.0 мянган төгрөг/												
9	Шторк, зар сурталчилгаанаас гадна хэвлэл мэдээллийн 8 байгууллагатай гэрээ байгуулж 74,700.0 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна.	1	74,700.0			1	74,700.0						
10	Үйл ажиллагааны чиглэл өөр байгууллагуудаас бараа материал худалдан авч, ажил үйлчилгээ зохион байгуулсан байна.	1	167,640.0			1	167,640.0						
11	Байгууллагын төсвөөр уралдаан тэмцээн зохион байгуулж 41,740.0 мянган төгрөгийн зардал гаргаж, үрэлгэн зарцуулсан байна	1	41,740.0	1	41,740.0	-	-	-	-	-	-	-	-
12	Байгууллагын удирдлага үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ашигтай ажилласан шалтгаанаар өөртөө давуу байдал үүсгэж их хэмжээтэй урамшуулал авсан байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
	Дүн	12	1,438,442.9	2	51,317.0	4	493,281.5	6	893,844.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
1	Хөрөнгө оруулалтын үр өгөөж, эдийн засгийн ач холбогдол, нэн шаардлага эсэхийг тооцохгүйгээр их хэмжээтэй компьютер 648,128.6 мянган төгрөг, тавилга 95,195.7 мянган төгрөг, фитнесийн тоног төхөөрөмж 162,207.7 оффист нэвтрэлтийн систем, программ, сайжруулалтад 833,774.0 мянган төгрөг нийт 1,739,306.0 мянган хөрөнгө авч, үрэлгэн зарцуулсан байна.	1	1,739,306.0					1	1,739,306.0				
2	Байгууллагад үүссэн хэрэгцээний ажлыг гэрээ шууд байгуулах аргаар хийж гүйцэтгэсэн нь үр ашигтай гэж зохион байгуулсан боловч тухайн ажил нь тухайн зорилгыг хангаагүй, гэрээнд заасан хугацаандаа үр дүнд хүрээгүй, гэрээт ажил хугацаандаа дуусаагүй,	1	1,121,984.4					1	1,121,984.4				

	шууд гэрээ байгуулах аргыг сонгох шаардлага нөхцөл байдал үүсээгүй байна.								
3	Хийх ажлын байрны чиг үүрэг нь тодорхой бус бүтээмжийн менежер гэсэн албан тушаалтан ажиллуулсан, хийсэн ажлын үр дүнг тооцоогүй байна.	1	68,840.6	-	-	-	-	1	68,840.6
	Дүн	3	2,930,131.0			2	2,861,290.4	1	68,840.6



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 239/Анх60141

Улаанбаатар хот

НТАГ-2026/137/НА-СТА-ОНӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын төсвөөр уралдаан тэмцээн зохион байгуулж 41,740,000.0 (дөчин нэгэн сая долоон зуун дөчин мянган) төгрөгийн зардал гаргаж, үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" тус гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хууль хэрэгжүүлээгүй, үрэлгэн зарцуулсан 41,740,000.0 (дөчин нэгэн сая долоон зуун дөчин мянган) төгрөгийг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дарга Ц.Төрхүү, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Т.Даваасүрэн нараар төлүүлж Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан дахь НТАГ. хүү торгуулийн орлогын МN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дарга Ц.Төрхүү, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Т.Даваасүрэн, ахлах нягтлан бодогч Б.Хишигжаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Н.БАТТОГОО

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Корпус, 5 давхар

1426110265



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 240/10260191

Улаанбаатар хот

ННАГ-2026/137/НА-СТА-ОНӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Түүвэрчилсэн тооллогоор 3 албаны 4 эд хариуцагчийн 77,402 ширхэг 5,307,761,300.00 (таван тэр бум гурван зуун долоон сая долоон зуун жаран нэгэн мянган гурван зуун) төгрөгийн агуулахад бэлэн байгаа сэлбэг, хангамжийн материалыг тооллого хийхэд нийт илүүдсэн 185,300.00 (нэг зуун наян таван мянга гурван зуун) төгрөг дутагдсан 9,391,700.00 (есөн сая гурван зуун ерэн нэгэн мянга долоон зуун) төгрөгийн сэлбэг, хангамжийн материал байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 72 дугаар зүйлийн 4-д "Тооллогын комисс дараах үүрэгтэй", 5-д "эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.7-д "Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан үрээдүүлсэн, хууль бусаар ашигласан" заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүүдсэн, дутагдсан хөрөнгийн 9,577,000.00 (есөн сая таван зуун далан долоон мянган) төгрөгийг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дарга Ц.Төрхүү, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Т.Даваасүрэн нараар төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан дахь НТАГ. хүү торгуулийн орлогын MN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110261

2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дарга Ц.Төрхүү, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Т.Даваасүрэн, ахлах нягтлан бодогч Б.Хишигжаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Н.БАТТОГОО

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 565/А0220191

Улаанбаатар хот

НТНГ 2026/137/НА-СТА-ОНӨГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд авлагаар нэмэгдсэн 66,686,300.00 (жаран зургаан сая зургаан зуун наян зургаан мянга гурван зуун) төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ..." 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" тус заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал", "оршин байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Авлага нэмэгдсэн, тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дарга Ц.Төрхүү, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Т.Даваасүрэн, ахлах нягтлан бодогч Б.Хишигжаргал нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Н.БАТТОГОО

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426091117



**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 566/А0260191

Улаанбаатар хот

НТАГ-2026/137/НА-СТА-ОНӨТ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шторк, зар сурталчилгаанаас гадна хэвлэл мэдээллийн 8 байгууллагатай гэрээ байгуулж 74,700,000.00 (далан дөрвөн сая долоон зуун мянга) төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.3-д "Хэвлэлийн захиалгын төлбөр", гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шторк, зар сурталчилгаанаас гадна хэвлэл мэдээллийн зардалд зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дарга Ц.Төрхүү, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Т.Даваасүрэн, ахлах нягтлан бодогч Б.Хишигжаргал нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Н.БАТТОГОО

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо; А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426091048



**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 509/А0260191

Улаанбаатар хот

НТГА-2026/137/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагааны чиглэл өөр байгууллагуудаас 167,640,000.00 (нэг зуун жаран долоон сая зургаан зуун дөчин мянга) төгрөгийн бараа материал худалдан авч, ажил үйлчилгээ зохион байгуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ...:", 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үйл ажиллагааны чиглэл өөр байгууллагуудаас, худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дарга Ц.Төрхүү, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Т.Даваасүрэн, ахлах нягтлан бодогч Б.Хишигжаргал нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Н.БАТТОГОО

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426091047



**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 588/А0260131

Улаанбаатар хот

НТАГ-2026/137/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагад үүссэн хэрэгцээний 1,121,984,400.00 (нэг тэр бум нэг зуун хоёр нэгэн мянга есөн зуун наян дөрвөн мянга дөрвөн зуу) төгрөгийн ажлыг гэрээ шууд байгуулах аргаар хийж гүйцэтгэсэн нь үр ашигтай гэж зохион байгуулсан боловч тухайн ажил нь тухайн зорилгыг хангаагүй, гэрээнд заасан хугацаандаа үр дүнд хүрээгүй, гэрээт ажил хугацаандаа дуусаагүй, шууд гэрээ байгуулах аргыг сонгох шаардлага нөхцөл байдал үүсээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10 дугаар зүйлийн 10.8-д "Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, хил хамгаалах, онцгой байдлын байгууллага, цагдаа, дотоодын цэрэг, хорих байгууллагын тусгай хэрэгцээний болон нийслэл хотын аж ахуй, инженер хангамжийн бараа, ажил, үйлчилгээг тухайн салбарын төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар гүйцэтгүүлэх, эсхүл хорих байгууллагын өөрийн хэрэгцээний ажлыг холбогдох хуулийн дагуу гүйцэтгүүлэх нь үр ашигтай гэж захиалагч үзсэн бол нээлттэй түндер шалгаруулалтын аргыг хэрэглэхгүй байж болно", 35 дугаар зүйлийн 35.1-д "Захиалагч дараах үндэслэлээр аж ахуй эрхлэгчдийн дунд хэлэлцээ хийх замаар гэрээ шууд байгуулж болно" заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даатан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тус ажил нь тухайн зорилгыг хангаагүй, гэрээнд заасан хугацаандаа үр дүнд хүрээгүй, гэрээт ажил хугацаандаа дуусаагүй, шууд гэрээ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426091042

- байгуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дарга Ц.Төрхүү, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Т.Даваасүрэн, ахлах нягтлан бодогч Б.Хишигжаргал нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨРСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



[Handwritten signature]
8/2025

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Н.БАТТОГОО

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 569/А0260191

Улаанбаатар хот

НТАГ - 2026 / 137 / НН - СТА - ОНӨАТ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөрөнгө оруулалтын үр өгөөж, эдийн засгийн ач холбогдол, нэн шаардлага эсэхийг тооцохгүйгээр их хэмжээтэй компьютер 648,128,600.00 (зургаан зуун дөчин найман сая нэг зуун хорин найман мянга зургаан зуу) төгрөг, тавилга 95,195,700.00 (ерэн таван сая нэг зуун ерэн таван мянга долоон зуу) төгрөг, фитнесийн тоног төхөөрөмж 162,207,700.00 (нэг зуун жаран хоёр сая хоёр зуун долоон мянга долоон зуу) төгрөг, оффист нэвтрэлтийн систем, программ, сайжруулалтанд 833,774,000.00 (найман зуун гучин гурван сая долоон зуун далан дөрвөн мянга) төгрөг нийт 1,739,306,000.00 (нэг тэр бум долоон зуун гучин есөн сая гурван зуун зургаан мянган) төгрөгийн хөрөнгө авч, үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.2-д "санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7-д "аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажиллаагүй, их хэмжээгээр хөрөнгө бэлтгэсэн, үрэлгэн зардал гаргасан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426091045

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дарга Ц.Төрхүү, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Т.Даваасүрэн, ахлах нягтлан бодогч Б.Хишигжаргал нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Н.БАТТОГОО

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 530/А0260111

Улаанбаатар хот

НТАГ-2026/137/НА-СТН-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын даргын тушаал шийдвэргүй, бараа материал устгасан акт үйлдээгүй, өмч хамгаалах байнгын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлд актлах материалыг хоёрдогч түүхий эдээр борлуулах, хогонд ачих зэргийг дурдаагүй нийт 4370 нэр төрлийн 184,255,200.00 (нэг зуун наян дөрвөн сая хоёр зуун тавин таван мянга хоёр зуу) төгрөгийн бараа материалыг данс бүртгэлээс хасаж тайлагнасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 72 дугаар зүйлийн 4-д "Тооллогын комисс дараах үүрэгтэй", 5-д "эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал", "оршин байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426091051

1. Бараа материалыг актлах тушаал шийдвэргүй гаргах, устгасан акт үйлдээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дарга Ц.Төрхүү, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Т.Даваасүрэн, ахлах нягтлан бодогч Б.Хишигжаргал нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨРСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Н.БАТТОГОО



Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар